

ДеФакто **ТОЙМ**

- БАЙГУУЛЛАГА БИШ ХУВЬ ХҮН ӨӨРӨӨ ТАТВАРАА ТӨЛДӨГ БОЛОХ УУ?
- ШҮҮХИЙГ ХЭН ШҮҮХ ВЭ?
- БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ БАГАССАНААР ББСБ-ЫГ ЗОРИХ УУ?

XI НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

ЭРДЭНЭБИЛЭГИЗМ II - МОНГОЛЫН АВЛИГЫН ЭЭЛЖИТ ДРАМ

II НҮҮРТ



САЙН ЗАСАГЛАЛ

О.Мөнхбат
Доктор, МУИС-ийн Профессор

УЛС ТӨРИЙН НАМ
АВЛИГЫН СИСТЕМИЙН

“ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ” БОЛСОН НЬ

VIII НҮҮРТ

ХОТЖИЛТ УУ ХҮН АМЫН ХЭТ ТӨВЛӨРӨЛ ҮҮ?

СУДАЛГАА



V НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2019.03.27, №90

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.defacto.mn

Эрдэнэбилэгизм II



ХУДАЛДАА
ХӨГЖЛИЙН БАНК



УЛААНБААТАР
ХОТЫН БАНК

МОНГОЛЫН АВЛИГЫН ЭЭЛЖИТ ДРАМ

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

ЭРДЭНЭБИЛЭГИЗМ II - МОНГОЛЫН АВЛИГЫН ЭЭЛЖИТ ДРАМ

Хүн амтайгаа харьцуулахад, улс төрийн драмын тоогоороо манай улс дэлхийд тэргүүлж яваа. Үнэн шударгын болон худал хуурмагын халуун, хүйтэн урсгалууд хавиралдан салхи шуурга үүсэхэд, монголыг бүрхсэн өтгөн хар МАНАН-г энд тэндээс нь сарниулж эхэллээ. Эрч хүч сулхан ч, энэ удаагийн

салхиар ил болж буй зарим нэг үйл явдлын цэгүүдийг он сар, логик дарааллаар нь холбож, нарийвчлан судлах, үнэн мөнийг мушгин хөөж, учир шалтгааныг нь тодруулах, урагшлах замаа засч, цэвэрлэх шаардлага нийгмийн өмнө тулгараад байна.

ХОЁР БАНКНЫ НЭГ ЭЗЭН

Улаанбаатар хотын банкны дүрмийн санг нь өсгөх Монголбанкны шаардлагаар түрий барин зөвхөн өөрийнхөө хувийг нэмэгдүүлж, эрх баригчидтай хуйвалдан нийтийн хөрөнгийг завшсан талаар би гурван жилийн өмнө [“Эрдэнэбилэгизм - Монгол ардчиллын шинэ үзэгдэл”](#) гэдэг нийтлэлдээ бичсэн. Дүрмийн санд нэмэлт хөрөнгө хэрэгтэй тухай иргэдэд (жинхэнэ эздэд) нь мэдэгдэхийн оронд Д.Эрдэнэбилэгт 80 хувийг нь хотын дарга асан М.Энхболд, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр нар ээлж дараалан, сүүлчийн 20 хувийг 2014 онд Э.Бат-Үүл тус тус зөвшөөрчээ.

Худалдаа Хөгжлийн Банкыг (ХХБ) хувьчилсан түүх Ерөнхий сайдуудтай холбоотой. 2002 онд энэ банкны 76 хувийг Ерөнхий сайд Н.Энхбаярын шууд оролцоотойгоор Жералд Металс компанид 12.3 сая доллараар зарав. 2007 онд Ерөнхий сайд М.Энхболдын оролцоотойгоор Д.Эрдэнэбилэг 70 сая доллараар эргүүлэн авлаа. Тэр одоо ХХБ-ны 93 хувийг өөрийн 100 хувь эзэмшдэг, гадаадад бүртгэлтэй 4 компанийн нэрээр, 5 хувийг Голдман Загс, 2 хувийг нь 50-аад иргэн эзэмшиж байна. ХХБ өнөөдөр МУ-ын хоёр дахь том арилжааны банк. Мөн улсын арилжааны банкуудын нийт хөрөнгийн 25 хувийг эзэлдэг.

Улаанбаатар хотын банк болон ХХБанкинд нийслэлийн засаг дарга асан МАН-ын М.Энхболд, Ц.Батбаяр, Г.Мөнхбаяр нар [“онцгой хайртай”](#) байсан.

Хотын төвийн, нийтийн эзэмшлийн, өндөр үнэлгээтэй олон газар, цэцэрлэгийг энэ хоёр банкны мэдэлд “шилжүүлдэг” байлаа. Хамгийн сүүлд Г.Мөнхбаяр 2012 оны сонгуульд нам нь ялагдсаны дараа, хотын шинэ захиргаа байгуулагдах хооронд наадмын өмнөх өдөр Улаанбаатар зочид буудлын өмнөх, Тагнуулын Ерөнхий Газрын өмнөх, Ю.Цэдэнбалын талбайн, Академич Б.Ширэндэвийн хөшөөтэй Оюутны талбайн цэцэрлэгүүдийг тус тус Улаанбаатар банкинд эзэмшүүлж “олон давхар газар доорх гарааш” бариулах а/495 тоот захирамж гаргаад оджээ.


ХХБ бас хотын нэгэн түүх болсон “Хүүхдийн номын санг” буулгаж, оронд нь шил бетон хийцийн дөрвөлжин байшин 27 тэрбум төгрөгөөр босгов. Тэгмэгцээ 11-12 давхрыг нь төрийн өмчийн Хөгжлийн банкинд 27 тэрбумаар, банк дийлэнх хувийг нь эзэмшиж байсан МИК компанид 10-р давхрыг нь 15 тэрбумаар худалджээ. Д.Эрдэнэбилэг төрийн өмчтэй байгууллагуудаас мөнгө босгох, тэдэнд бараа үйлчилгээ борлуулдаг хосгүй “авьяастнаар” тодроод байна.

Энэ хүн бас Монгол улсын төр засгийг ээлжлэн болон эвсэн барьж ирсэн МАН болон АН-ыг хоёуланг нь санхүүжүүлэгчдийн нэг гэдэг. Хоёр нам санхүүжүүлэгчдийнхээ нэр, хандивын хэмжээг онцгой нууцалдаг. МАНАН бол монголын төр засгийн авлигын үүр.

МОНОПОЛИ ТОГТООХ ЗАМД

ХХБ нь улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Гэхдээ нууцлаг эзнийхээ компаниудад бүр томоор, онцгой үйлчилж ирсэн нь УИХ дээр танилцуулсан Эрдэнэтийн 49 хувийг худалдан авах мөнгө босгосон бүдүүвч зургаас тодров.





Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, “Монголросцветмет” компанийн 49 хувийг ОХУ-аас худалдан авахдаа “Монголиан Коппер Корпорейшн” төрийн хөрөнгийг ашигласан тухай Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газрын дарга Л.Оюун-Эрдэнэ дээрх бүдүүвчээр тодорхой харуулав.

Нийт 400.2 сая америк долларын 30 хувийг Сангийн яам, Монголбанк, Хөгжлийн банкнаас гаргуулж Д.Эрдэнэбилэгийн өөрийнх нь “Кью Эс Си” компаниар дамжуулан босгожээ. Үлдсэн 70 хувийг ХХБ мөн л гол эзэнтэй нь болон төрийн сайд, хотын даргатай холбоотой дөрвөн компанид зээл олгох замаар дамжуулан “Монголиан Коппер Корпорейшн” компанид шилжүүлжээ.

Эрдэнэт үйлдвэрийг мэдэлдээ авсны дараа 2016 оны 3-8-р сарын хооронд үйлдвэрээс нь бараа худалдан авах, өмнөх жилүүдийн ногдол ашиг хуваарилах зэргээр 120 сая доллар гаргуулж, нэмж Монголбанкнаас 78 сая долларын “зузаатгал?”, Сангийн яамнаас 72 сая

МАФИЙН ТОГТОЛЦОО

Авлигын хэргийг шүүх, хүчний байгууллага нь хамгаалдаг улсад мафиин тогтолцоо үүссэн гэж үздэг. Нийтийн хөрөнгийг хууль бусаар ашигласан талаар Засгийн газрын гаргасан гомдлыг монголын шүүх, прокурор дөрвөн удаа ч хэрэгсэхгүй болгов.

Монголын шүүхийн шийдвэрийг гаргасан шүүгчдийг Засгийн газар ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байна. “Монголиан Коппер Корпорейшн”-д ХХБ-аас авсан 75 сая долларын зээлийнхээ 70 саяыг нь авсан өдрөө шилжүүлсэн “Юнайтед Энержи” компанид захирлаар ажиллаж байсан Д.Мишигийн хүү, шүүгч М.Батсуурь Засгийн газрын гомдлыг 3 удаа хэрэгсэхгүй болгожээ. Энэ тухай Засгийн газар АТГ-т хандсан боловч тусыг эс олжээ.

долларын зээл тус тус аваад ХХБ гаргасан зээлээ хаажээ.

Ийнхүү нийтийн хөрөнгөөр 49 хувийг авсан учир, төр засагтай харилцан өглөг авлагаа тооцоод төрд шилжүүлэх УИХ-ын шийдвэр гарсан ч “Монголиан Коппер Корпорейшн” компани хүлээн зөвшөөрөхгүй шүүхдсээр хоёр жил болж байна.

ХХБ-ыг барьцаагүй зээл олгосон, хамааралтай этгээдэд өндөр дүнтэй зээл олгох зэргээр банкны хууль зөрчсөн гэж төр засаг нь үзэж байгаа ч шалгах эрхийг шүүх олгохгүй, удирдлагуудыг нь баривчилсан боловч хууль бус гэж үзээд суллуулав.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж Д.Эрдэнэбилэгийн хоёр банкны мэдэлд эдүгээ уул уурхайн 37, зөвхөн “Монголросцветмет” компанид Асгатын мөнгөний ордоос Бор өндөр хүртэлх олон аймаг дамжсан нутгийг хамарсан 35, нийт 70 гаруй лиценз байгаа. Мөн Дарханы төмөрлөг, Эрдэнэт, Дархан Сэлэнгийг тойрсон олон орд газар байгаа гэж мэдэгдэв.

Мөн Засгийн газар нь санхүүгийн эх үүсвэртэй атлаа 49 хувийг худалдан авах боломжгүй гэж сайн дурын үндсэн дээр татгалзсаныг АТГ шалгахгүй хойш суусаар иржээ.


Аргаа барсан төр засаг Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл дээр асуудлыг хэлэлцээд холбогдох хуульд өөрчлөлт оруулж шүүх, прокурорын удирдлагыг солих гэж УИХ өдөр шөнөгүй яг одоо хуралдаж байна.

Шүүх, прокурор, АТГ-ын даргаа сольсон ч Монгол улс төр засгийг нь барьцаалсан аймшигт мафи, авлигаасаа хэзээ салах бол оо?

The Defacto Gazette

INFORMING | INSPIRING | EMPOWERING

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН



2019 ОНЫ II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

УЛИРЛЫН ЗАХИАЛГА: 30.000₮



МОНГОЛ
ШУУДАН

7007-8916



ХОТЖИЛТ УУ ХҮН АМЫН ХЭТ ТӨВЛӨРӨЛ ҮҮ?



“Улаанбаатар хот: Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2019”-ийн үр дүнгээс

*Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс
“Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан 2019” судалгааг хоёр
дахь удаагаа гарган үр дүнг танилцууллаа.*

Улс орны хөгжлийн явцад гарч ирдэг зайлшгүй нэгэн үзэгдэл нь хотжилт бөгөөд хөгжил, дэвшил, шинэчлэлт гэдэг үгстэй утга нэг ойлгогддог. Бид хотжилтыг хөдөө орон нутгаас шилжин ирэх хүний тоо нэмэгдэх төдийхнөөр ойлгодоггүй харин илүү сайн амьдралын стандарт, илүү боломж гэж хардаг.

Харин Монгол улсын хувьд ‘хотжилт’ гэх үзэгдэл яг хэрхэн тодорхойлогдож, ямар үр нөлөөг дагуулж байна вэ?

Хотжилт иргэдийн амьдралыг сайжруулж, хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд нь туслаж чадаж байна уу?

Манай улсын нийт хүн амын 67.2 хувь нь хот суурин газар, үүнээс 45.3 хувь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл хотод амьдарч байна. Тэр дундаа нийслэл хотын нийт хүн амын 95.1 хувь нь төвийн 6 дүүрэгт амьдарч буй юм¹.

Нийт нутаг дэвсгэрийн ердөө 0.3 хувийг эзлэх Улаанбаатар хотод хүн амын дийлэнх нь төвлөрч буйгаас харахад



хотжилт үнэхээр эрчимтэй байна. Харин хотжилтын үр нөлөөг үнэлэхийн тулд түүнийг зөв тодорхойлох, олон талаас нь бодитоор хэмжих нь чухал. Улаанбаатар хотын дүүргүүдийн өрсөлдөх чадварын судалгааны үндсэн зорилго нь энэ билээ.

¹ Монгол Улсын хүн амын статистик, 2017, Үндэсний статистикийн хороо

УЛААНБААТАР ХОТЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ИНДЕКС

Дүүргүүдийн өрсөлдөх чадварыг судлаж эхэлсэн 2 жилийн өмнөхтэй харьцуулахад нийслэл хотын хүн ам 2.7 хувь нэмэгдэж 1.4 сая иргэнтэй, 386 мянган өрхтэй болжээ².

Улаанбаатар хотын өрсөлдөх чадварын ерөнхий индекс 0.557 болж, 2017 оны судалгаатай харьцуулахад 7 хувь нэмэгдсэн байна. Өрсөлдөх чадварын индекс нь 0-1 хооронд утга авах ба 1 рүү дөхөх тусам өрсөлдөх чадвар сайтай гэж үздэг.



Улаанбаатар хотын өрсөлдөх чадварыг үндсэн 5 бүлгээр харвал эдийн засаг, амьдралын чанарын хувьд харьцангуй сайн буюу 0.6-аас дээш оноотой, харин аюулгүй байдал, засаглал 0.5 орчим, амьдрах орчны хувьд 0.5-аас бага оноотой үнэлэгдсэн байна.

Манай улсын эдийн засгийн гол цөм нь яахын аргагүй Улаанбаатар хотод төвлөрч байна. Нийт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын 64.2 хувь нь нийслэл хотод төвлөрч, улсын нийт ДНБ-ий 64.7 хувийг энд бүрдүүлж байна³. Дүүргүүдийн

судалгааны үр дүнгээс харвал эдийн засгийн төвлөрөл өндөр, иргэдийн амьжиргааны түвшний өөрчлөлтийн талаарх хүлээлт эерэг байгаа боловч ажилгүйдлийн түвшин өндөр, үнийн өсөлтийн иргэдийн амьжиргаанд үзүүлэх дарамт их хэвээр байна. Нийт өрхийн 39 хувь нь сард 500 мянган төгрөгөөс доош орлоготой байна.

Улаанбаатар хотыг зорих гол шалтгаанууд болох эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, эмнэлэг, сургуулийн орчин, нөхцөл хөдөө орон нутагтай харьцуулахад сайн байгаа хэдий ч эмнэлгийн

ачаалал өндөр байгааг судалгааны үр дүнгээс харж болно. Мөн ЕБС-ийн хамран сургалт сайн байгаа бол цэцэрлэгийн хамран сургалтын хувь тун хангалтгүй гарчээ. 2017 оны байдлаар Улаанбаатар хотын хэмжээнд 2-5 насны нийт хүүхдийн 78 хувь нь цэцэрлэгт хамрагдаж байна. Мөн төрийн өмчийн цэцэрлэгийн сурагч багшийн харьцаа өндөр (нэг багшид ногдох сурагчийн тоо 38) байна. Цэцэрлэг, сургуулийн хүртээмж өмнөх судалгаатай харьцуулахад сайжирч байгаа хэдий ч хүн амын өсөлтийн хурдыг гүйцэхгүй байна.

УЛААНБААТАР ХОТ ХЭР АЮУЛГҮЙ, АМАР ТАЙВАН ХОТ ВЭ?

Хүн амын тоотой харьцуулж харвал нийслэл хотод гэмт хэргийн тоо хөдөө орон нутгаас өндөр байдаг. Түүнчлэн 2 жилийн өмнөх судалгаатай харьцуулахад гэмт хэргийн гаралт нэмэгдсэн, илрүүлэлт буурсан байна. Харин залуусын гэмт хэрэгт холбогдох байдал багасах хандлагатай болжээ. Мөн хууль ёс хүн бүрт тэгш үйлчлэх байдлыг иргэд 3.8 оноогоор үнэлсэн нь тун тааруу үзүүлэлт байна.

Аюулгүй амьдрах нэг нөхцөл нь эрүүл, цэвэр орчинд амьдрах явдал билээ. Гэтэл Улаанбаатар хотын иргэд эрүүл орчинд амьдарч чадахгүй байна. Агаарын бохирдол, ил задгай хог хаягдал, дуу чимээний

бохирдол зэрэг үзүүлэлтийн үнэлгээ доогуур байгаа нь үүнийг илтгэж буй юм.

Хотжилтын нэг том давуу тал нь ая тухтай амьдралын стандартыг бий болгох байдаг. Одоогийн байдлаар Улаанбаатар хотын нийт өрхийн 44 хувь нь орон сууцанд буюу төвлөрсөн системд холбогдсон бол 27 хувь нь монгол гэрт амьдарч байна. Хамгийн сонирхолтой нь энэ үзүүлэлт 10 жилийн өмнөхтэй харьцуулахад бараг өөрчлөгдөөгүй (2007 онд нийт өрхийн 26 хувь нь монгол гэрт амьдарч байсан⁴) байгаа юм.

² Улаанбаатар хотын хүн амын статистик, 2015, 2017 он, Нийслэлийн статистикийн газар

³ 2017 оны байдлаар, Үндэсний статистикийн хороо

⁴ Нийслэлийн статистикийн эмхтгэл, 2007, Нийслэлийн статистикийн газар

ИРГЭД ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ОНОВЧТОЙ БАЙДАЛД ДУНД ҮНЭЛГЭЭ ӨГЧ БАЙНА

Ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний зам зэрэг үзүүлэлтүүд тун хангалтгүй байгаа нь уг үнэлгээнд нөлөөлжээ.

Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад дүүрэг, хорооны цахим засаглал, мэдээллийн нээлттэй байдал нэмэгдэж, түүнийг даган дүүрэг, хорооны үйл ажиллагааны хүртээмж сайжирсан хэдий ч дүүргүүдийн төсвийн удирдлага, иргэдийн төсвийн эрх

мэдэл сул хэвээр байна.

Ийнхүү нэг талаас хотжилт эрчимжих буюу хотод амьдрах иргэдийн тоо, хүн амын нягтрал нэмэгдэх үзэгдэл явагдаж байна. Харин хотжилтын чанарын хувьд хотод амьдарч буй иргэдийн амьдралын стандарт нь хүн амын өндөр нягтралаас хамааран буурахгүй байх, сонголт хийх боломж нь хязгаарлагдахгүй байх учиртай ч энэ нь бодит байдалд

төдийлөн хангагдахгүй байна.

Хотжилт илүү сайн амьдралын стандартыг сонгох боломжийг нээж байгаа нь үнэн ч энэ нь хүн бүрт хүртээмжтэй бус байна. Хотжилтын эерэг нөлөөг илүү хүртээмжтэй байлгах, хотын болон дүүргүүдийн өрсөлдөх чадварыг тогтвортой хөгжүүлэх нь урт хугацаанд анхаарах гол асуудал гэж дүгнэсэн.

ДҮҮРГҮҮДИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ЯЛГААГ ЕРӨНХИЙД НЬ ГУРВАН ТҮВШИНД АНГИЛАВ


Үүнд өрсөлдөх чадварын хувьд харьцангуй сайн буюу Хан-Уул, Баянгол, Баянзүрх дүүргүүд (өрсөлдөх чадварын индекс нь 0.510-аас дээш оноотой), өрсөлдөх чадварын хувьд дундаж Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргүүд (өрсөлдөх чадварын индекс нь 0.460-0.510 хооронд оноотой) болон алслагдсан дүүргүүд болох Багануур, Налайх, Багахангай дүүрэг (өрсөлдөх чадварын индекс нь 0.460-аас бага) гэж ангилж болохоор байна.

Өөрөөр хэлбэл нийслэл хотын дүүргүүдийн өрсөлдөх чадвар харилцан адилгүй хэмжээнд байгаа нь мөн анхаарал хандуулах асуудал гэж харагдаж байна.

Улаанбаатар хотын өрсөлдөх чадварыг сайжруулах, дүүргүүдийн өрсөлдөх чадварын ялгааг арилгахын тулд судалгааны үр дүнг тогтмол хэмжиж, өрсөлдөх чадварын сул үзүүлэлтэд илүү анхаарал хандуулан ажиллах шаардлагатай. Энэ судалгааны зорилго нь дүүргүүдийг өрсөлдүүлэхэд бус харин хөгжлийн ялгаа хэр их байна, өрсөлдөх чадварын өнөөгийн түвшин ямар байна, давуу болон сул тал нь юу вэ гэдгийг гаргаж ирэхэд чиглэсэн. Нөгөөтэйгүүр тайланд багтсан 150 шалгуур үзүүлэлт бүрийг нарийвчлан авч үзэж тухайн үзүүлэлтийг сайжруулахын тулд юу хийх ёстой талаар бодлого боловсруулагчид, хувийн хэвшил, иргэд санал, санаачилга гарган ажиллах нь зүйтэй юм.

Хүн амын хэт төвлөрлөөс үүдсэн асуудлаар дүүрэн бус харин хүн бүр сэтгэл хангалуун амьдрах боломжоор дүүрэн хотыг бид хүсч байна.

Дүүргүүдийн өрсөлдөх чадварын ерөнхий индекс 2019



2019 оны 3-р сар

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ДАРААХ ХАЯГААР ХОЛБОГДОН АВАХ БОЛОМЖТОЙ:

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв
Вебсайт: www.ecrc.mn | www.aimagindex.mn | www.nogoonhutuch.mn

Цахим шуудан: info@ecrc.mn

Утас: 976-11-321927

Факс: 976-11-321926





О.МӨНХБАТ

Доктор, МУИС-ийн Профессор

НИЙТЛЭЛ

УЛС ТӨРИЙН НАМ АВЛИГЫН СИСТЕМИЙН “ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ” БОЛСОН НЬ

АСУУДЛЫГ ДЭВШҮҮЛЭХҮЙ

Монгол улсад авлига тогтолцоо, систем болон хувирч нийгмийн шударга ёсны бүх л тогтолцоог сөрөн зогсож чадахуйцаар хүчирхэгжиж байна. Авлигыг тогтолцоо болж хувирахад улс төрийн нам, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал болон дөрөв дэх засаглал гэгдэгч хэвлэл мэдээлэл, “хармааны” иргэний нийгмийн байгууллагуудын хууль бус “түншлэл” улс төр, эдийн засгийн олигарх бүлэглэлийг үүсгэсэн явдал голлох үүрэг гүйцэтгэж байна. Эдгээрээс улс төрийн нам нь В.Ленины үгийг багахан засаад хэлбэл “манай эрин үеийн мөнгө хөрөнгө, эрх мэдэл, албан тушаал” болон хувирсан нь Монголын “үзэгдэл” боллоо.

УЛС ТӨРИЙН НАМ АВЛИГЫН “ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ ” БОЛСОН НЬ

Монголын улс төрийн намуудын нийтлэг шинж бол

1. өргөн олны гишүүнчлэлтэй байх
2. гишүүнчлэл, харьяаллаар нийгмийн бүх хүрээ, бүлгүүдэд хяналт тогтоох
3. намын харьяалал нь давуу эрх ямба олгодог
4. жирийн гишүүдийн нэрийн өмнөөс “сонгогдсон цөөнх” ноёлох гэсэн шинжүүд аж.

Чухамхүү монголын төр засгийн дээр гарсан энэхүү олон нийтийн байгууллага нь авлигын тогтолцоог санаачлан бэхжүүлж, хөтлөн урагшлуулагч болсны гол шалтгааныг түүний санхүүжилтийн ил тод бус байдал гэж байгаа нь чухамдаа “нуухыг нь авах гээд нүдийг нь сохлохын үлгэр” санагдана.

Ил болгохыг хүсч буй тэр санхүүжилт хаанаас, яагаад гараад ирэв гэсэн асуултыг зөв хариулахгүйгээр бид хол явахгүй. Харин шалтгаан нь бол төрийн эрх мэдэл, албан тушаал баяжих хөрөнгөжих үндэс болж, улмаар арилжааны хэрэгсэл болон хувирсанд байгаа бус уу. Албан тушаалын хуваарилалтыг мерит шударга зарчим бус намын харьяалал, хувийн үнэнч байдалд тулгуурлан хийх болсонд байгаа бус уу.

Улс төрийн намууд эрх мэдэл албан тушаалд түшиглэсэн авлигын тогтолцоог хэрхэн бий болгосныг товчоор харцгаая.

ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГА СИСТЕМ БОЛОХ НЬ

Монгол улсад авлига бүхэл нийгмийн тогтолцоог гажуудуулж, завхруулахын хэрээр улам бүр нарийсч засаглалтай хутгалдан, зохион байгуулалттай, систем болон хувирч, өндөр түвшний авлига болжээ.

Өндөр түвшний авлигыг

1. **Оролцогч талууд:** Улс төрийн нам, өндөр дээд албан тушаалтан, шийдвэр гаргадаг институци оролцдог,
2. **Хөндөж буй эрх ашиг:** Улс орон ард түмний язгуур эрх ашгийг хөнддөг,
3. **Үр дагавар:** Улс үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдалд хор хөнөөл учруулдаг

гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан тодорхойлж байна.

Ингэхдээ авч өгч байгаа авлигын мөнгөний хэмжээгээр бус харин улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, ард олны сайн сайханд байдалд заналхийлж буй гэмт хэрэг гэдэг утгаар нь авч үзүүштэй. Үүний зэрэгцээ өндөр түвшний авлига бол төрийн өндөр дээд албан тушаалтан оролцдог, хор хохирлын хувьд асар их, нарийн зохион байгуулалттай, голдуу хуулийн “хамгаалалтанд” орсон байдаг тул илрүүлэх, шалгах, хариуцлага тооцоход хүндрэлтэй байдгаараа онцлог юм.

НИЙГМИЙН СИСТЕМ БОЛОН ӨНДӨР ТҮВШНИЙ АВЛИГЫН ҮНДСЭН ШИНЖ ЧАНАРУУД

Өндөр түвшний авлига яагаад тогтолцоо систем болдог талаар судлахдаа бид эхлээд системийн өөрийнх нь үндсэн шинж чанарыг социологийн эрдэмтэн судлаачид хэрхэн авч үздэгийг хөндөн ярья.

Системийн онолын томоохон төлөөлөгч Т.Парсонс аливаа системийн шинж чанарыг дараах байдлаар тодорхойлсон байна. Түүний үзсэнээр систем нь:

- ♦ Системийн хэсгүүд нь өөр хоорондоо харилцан хамааралтай, эмх цэгцтэй байдаг
- ♦ Систем нь тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах чадвартай байдаг
- ♦ Систем нь статик тогтвортой байдлыг хадгалахын сацуу эмх цэгцтэй өөрчлөлтөнд орох чадвартай байна
- ♦ Системийн нэг хэсгийн мөн чанар нь нөгөө хэсгүүддээ нөлөө үзүүлэх чадвартай байдаг
- ♦ Систем нь хүрээлэн буй орчноосоо зайгаа барьж, хил хязгаараа хадгалдаг
- ♦ Хуваарилалт болон интеграчлал нь системийн тэнцвэртэй байдлыг хадгалах суурь үндсэн үйл явц
- ♦ Систем нь орчноос зайгаа хадгалах, бүхлийн хэсгүүдтэй харилцаанд орох, өөрчлөлтөнд орох хандлага хийгээд хүрээлэн буй орчны олон талт байдлыг хянах чадвартай байдаг аж¹.

¹ Ritzer.G(1996) Sociological theory. (4th ed) New York: The McGraw-Hill. p 240

Тэгвэл өндөр түвшний авлигын үндсэн шинжийг энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийж мэргэшсэн шинжээчид мөн л

1. Өндөр зохион байгуулалт бүтэц бүхий
2. Төрийн өндөр дээд албан тушаалтан, эрх мэдэлтнүүд оролцдог
3. Хууль цаазыг өөртөө ашигтайгаар завхруулан ашиглаж, хуулийн хамгаалалт дор байдаг зэрэг үндсэн шинжээр тодорхойлж байна.

Ингээд өндөр түвшний авлигыг нийгмийн системтэй харьцуулан үзье.

Нийгмийн системийн гол шинж	Өндөр түвшний авлигын системийн шинж
Бүтэц зохион байгуулалт	Бүтэцжсэн, өндөр зохион байгуулалттай, үндэсний болоод үндэстэн дамнасан орон зайд үйлчилдэг
Хүчирхэг нөлөөтэй тоглогч, оролцогч талууд	Улс төрийн нам, Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглал, болон бизнесийн нөлөө бүхий институци оролцдог
Дасан зохицох, гадаад орчинг өөрт ашигтайгаар өөрчлөх чадвартай	Хуулийн тусламжтай болон хууль бусаар давуу байдлыг бий болгож, шударга ёс, нийтийн “сонирхол” –оор бамбайлан хаацайлдаг
Гадаад орчноос өөрийгөө хамгаалах чадавч /дархлаа/	Хууль бус зан үйлийг зөвтгөх, хуулийг завхруулах хүчирхэг хөшүүрэг, эрх мэдэл бүхий, шийдвэр гаргах түвшинд нөлөөллийн бүлгүүдтэй, “халдашгүй байдал” зэрэг эрх зүйн хамгаалалттай

Өндөр түвшний авлигын тогтолцоо болохын хувьд өөрийн бүрэлдхүүн хэсгүүд, тэдгээрт оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн функцийг гүйцэтгэдэг аж. Өндөр түвшний авлигад оролцогч талууд нь авлигын системдээ дараах байдлаар үйлчилдэг байна.

Тухайлбал,

Улс төрийн нам: Сонгуулийн дэмжлэгийн хариу барих, төр засгийг бүхэлд нь хяналтандаа авч, засаглалын бүхий л түвшний хуваарилалтыг хийх, “эргэдэг хаалга”-ны зарчмаар үйлчилнэ.

Хууль тогтоох байгууллага: Авлигад “ээлтэй” бодлого, хууль эрх зүйн орчин “бүрдүүлэх”, халдашгүй байдал, өршөөл үзүүлэх гэх мэт “хамгаалалтын” нөхцөл бий болгох зэргээр үйлчилнэ.

Гүйцэтгэх байгууллага: Хуулийн хэрэгжилтийг гажуудуулан завхруулах, хууль бус давуу байдал олгох зэргээр үйлчилнэ.

Шүүх, хууль хяналтын байгууллага: Хуулийн өмнө тэгш байх зарчим, шударга ёсыг алдагдуулж, “дуулгаваргүй”-г номхотгох, “халдашгүй”-г хамгаалах зэргээр үйлчилнэ.

Бизнесийн бүлэглэл: Улс төртэй хутгалдах замаар олигарх бүлэглэл үүсгэх, улс орны эрх ашиг, аюулгүй байдлыг хохироосон бизнес төслийг хэрэгжүүлж, том хөрөнгө оруулалтыг хяналтандаа авах, байлгах зэргээр үйлчилнэ.

Хэвлэл мэдээлэл: Олон нийтийн “Тархи угаалт”-ыг явуулж, “Хаалтын гэрээ” байгуулах зэргээр авлигачдыг хаацайлах үйлчилгээ үзүүлнэ.

“Халаасны” иргэний нийгэм: Авлигачдын халаасанд багтсан иргэний нийгмийн байгууллага олон нийтийн оролцоог хангах, ардчилал шударга ёс байгаа мэт дүр эсгэлтийг харуулан жүжиглэнэ. Ийнхүү “ашиг сонирхлоор” нөхцөлдсөн өндөр түвшний авлигачид харилцан биедээ дэм үзүүлэх байдлаар чухамдаа “аалзны тор” мэт бат бөх сүлжээ үүсгэн оршин байдаг ажээ.

Өндөр түвшний авлига, түүний гол оролцогчдын хувьд авлигын системийн тогтвортой байдлыг хангахдаа:

1. Улс төрийн нам, сонгуулийн тогтолцоог ашиглан засаглал эрх мэдэл олж авах
2. Албан тушаал, эрх мэдэл хуваарилах, тэдгээрийн тусламжтайгаар оролцогч талуудыг хянаж байх
3. Нэгдмэл ашиг сонирхол үүсгэх, түүнээ хамгаалах үүднээс зөрчилд орж болзошгүй хүчтэй талуудтай, тэр бүү хэл сөрөг хүчинтэй хууль бус гэрээ хэлцэл, хуйвалдаан, тохиролцоо хийх зэргээр ажилладаг байна.

АВЛИГЫН СИСТЕМИЙН ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ НАМЫГ ХЭРХЭН ШИНЭЧЛЭХ ВЭ?

Өндөр түвшний авлигын тогтолцооны “хөдөлгөгч хүч” улс төрийн намыг эрүүлжүүлэх шаардлагатай байна. Эдүгээ засгийн эрх барьж байсан болон барьж байгаа улс төрийн намууд шинэчлэгдэх оролдлого хийж байсан, хийж байгаа боловч амжилтанд хүрсэнгүй. Учир нь тэд намыг авлигын хөдөлгөгч хүч болоход хүргэсэн суурь нөхцлүүдээ өөрчилж чадаагүй. **Энэ нь:**

- ♦ Нэгдүгээрт, улс төрийн намын гишүүнчлэл. Улс төрийн намын гишүүнчлэл нь гишүүн жирийн олонхид ямар нэг ашиг хонжоо өгөхөөс илүүтэй ноёлогч цөөнхийг хамгаалах хэрэгсэл буюу далласан газар ил гарч далайсан газар далд ордог масс бий болгож байна. Түүнчлэн нам нэгтнүүд “таньдаггүй бурхнаас таньдаг чөтгөр дээр” гэсэн зарчмаар хандаж, ардчилсан сонгуулиар хамгийн сайныг өрсөлдүүлэн сонгох зарчмыг үгүйсгэжээ. Мөн намын харьяалал нь нам нэгтнээ барьцаалан шантаажлах боломжийг нээж “аяганы хариу өдөртөө, агтны хариу жилдээ” гэсэн зарчмыг бэхжүүлж байна. Улмаар намууд бодлогоор өрсөлдөх бус аль болох

олон гишүүн элсүүлэх, эмэгтэйчүүдийн, залуучуудын зэрэг байгууллагуудыг олноор байгуулж нийгмийг бүхэлд нь улс төржүүлэн өрсөлдөж байна.

- ♦ Хоёрдугаарт, Нам нь сонгуулиар олж авсан хууль тогтоох эрх мэдлээ төр засгийн бүхий л албан тушаалыг хуваарилах эрх хэмээн ойлгох хандлага. Үүнээс үүдэн Монгол төр засгийн том жижиг бүх албан тушаалтан ялсан нам түүний эрх мэдэлтнээс хамааралтай болон хувирч, түүний хүсэл зоригт нийцүүлэн “алба” барих үүрэг хүлээнэ. Багаа бүрдүүлэх, багаар ажиллах хэмээх сайхан зарчим нь хувийн үнэнч шинж дээр суурилсан, баяжих хөрөнгөжих ашиг сонирхлоор нэгдсэн бүлэглэлээр солигдож, авлигын тогтолцоо бэхэждэг байна.

Эцэст нь, системийг зөвхөн систем ялдаг тул шударга ёсыг нийгмийн системийн хүрээнд тогтоосноор бид өнөөгийн мухардмал байдлаасаа гарах буй заа. За энэ бол бас өөр сэдэв биз ээ.

2019 оны 3-р сар



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.03.24-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

БАЙГУУЛЛАГА БИШ ХУВЬ ХҮН ӨӨРӨӨ ТАТВАРАА ТӨЛДӨГ БОЛОХ УУ?

Үйл явдлын товч:

Жил гаруй хугацаанд хэлэлцүүлэг өрнүүлсэн Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиудын (татварын багц хууль) шинэчилсэн найруулгыг УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэж, эцэслэн баталлаа.

Захиргааны шинжтэй байна, татварын бааз сууриа нэмэгдүүлэх дорвитой алхмуудыг хийгээгүй байна гэсэн шүүмжлэл олон нийтийн дунд яригдаж байсан.

Дүгнэлт тайлбар:

Татварын багц хуулийг шинэчлэх ямар зайлшгүй шаардлага тулгарсан бэ?

Татварын ерөнхий хууль гэж яг юу хэлээд байгаа юм бэ гэхээр Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоож, монголын Татварын алба, татвар төлөгч, энэ хуультай холбогдсон бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулна гэсэн үг.

Татварын хууль гэдэгт татварыг авах тухай л ярьдаг. Яах гэж авч байгаа юунд зориулахыг нь тодорхой болгох нь оновчтой. Жишээ нь орон нутагт хураасан ямар татварын хэдэн хувийг нь үлдээх вэ? Нийслэлээс алслагдсан бол орлогын татвар их бага байна гэдгийг аймаг бүсээр нь тооцсон нь дээр.

Гэхдээ хуулийн өөрчлөлт эдийн засгийн хөгжлийг, юуны өмнө үнэ цэнэ бүтээгч хувийн бизнесийг дэмжиж байна уу, эсвэл саад болохоор байна уу? гэдгийг тооцох ёстой. Яагаад гэвэл төсөв алдагдалтай гармагц, төр татвараа нэмдэг. Татвар нэмэгдэхээр, компани үнээ нэмдэг учир, нэмсэн татварыг компани биш хэрэглэгч төлдөг. Хэрэглэгч авч буй үнэ цэнээсээ илүү их төлбөр төлдөг гэсэн үг.



Дараагийн гэм биш зан болсон нэг зүйл бол өндөр татвар тавьчихаад алагчлан хөнгөлөөд байх уу? гэдэг асуудал. Үүний процессийн зардал их өндөр болдог.

Хууль батлахад ил тод, нээлттэй байх; олон нийтийн оролцоог хангах; ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх; гэсэн 4 зарчмыг баримтална гэсэн Хууль тогтоомжийн тухай хуулийг 2015 оны 5-р сарын 29-нд баталсан. Гэвч судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх гэсэн зарчим нь яригдахгүй л байна.

Монголын түүхэнд анх удаа Сангийн сайд нь "цаашид иргэдийнхээ орлогын мэдээллийн системийн бүртгэлтэй болж, улмаар хувь хүн бүрт татвар төлөгчийн дугаар олгох бодлогыг барина. Ингэснээр иргэдийн орлогын түвшинг харгалзан тодорхойлж, бага орлоготой иргэдийн төлсөн татварыг буцаан олгодог олон улсын жишгийг нэвтрүүлнэ" гэж хэлсэн. Энэ бол шинэчилсэн хуулийн сайн тал. Яагаад гэвэл хувь хүн өөрөө татвараа төлдөг дугаартай болсноор хэдий хэмжээний мөнгө улсад өгч байгаагаа ойлгож, хэнээс юу шаардахаа мэддэг болох юм.

Хамгийн гол татвар төлөгчид болох бизнес эрхлэгчдийн зүгээс анхаарах ёстой зүйл нь юу вэ?

Бизнес эрхлэгчид төлж байгаа татвартаа онцгой анхаарч, татварын хуулийг өөрчлөх тутамд идэвхтэй оролцох хэрэгтэй. Яагаад татвар

төлөх ёстой вэ гэдгийг бодох хэрэгтэй. Татвар авч буй гол зорилго нь төрийн үйл ажиллагааг л

санхүүжүүлэх. Харин төр юу хийж байгааг татвар төлөгч бүр төрөөс асууж, шаардах эрхтэй.

ШҮҮХИЙГ ХЭН ШҮҮХ ВЭ?

Үйл явдлын товч:

Өнгөрсөн Пүрэв гарагт Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж Эрдэнэт үйлдвэр болон С.Зориг агсны хэрэгтэй холбоотой мэдэгдэл хийсэн. Тухайлбал Засгийн газраас “Эрдэнэт үйлдвэр ХХК-ийг “улсын үйлдвэрийн газар” гэх статустай болгох шийдвэр гаргасан гэдгийг мэдэгдсэн. С.Зориг агсны хэргийн хувьд эрүүдэн шүүлттэй холбоотой асуудал ярьсан. Ер нь маш товчхондоо шүүх засаглалын асуудлуудыг энэ хоёр үйл явдлаар дамжуулж харуулаад, тогтолцоог нь өөрчлөх хэрэгтэй болчихжээ гэдэг мессежийг өглөө.

Дүгнэлт тайлбар:

Засгийн газраас Эрдэнэт үйлдвэрийг 100 хувь төрийн өмчит болгосон нь ямар учиртай вэ?

Хөрөнгө, өмчтэй холбоотой асуудлыг шүүхээр шийдэх ёстой. Гэтэл Засгийн газар, Их хурал өөрсдөө шийдэж байна. Нэг талаас хойшлуулшгүй гэж тайлбарлаж байна. Харин нөгөө талаас харвал шүүх нь тавьсан хүсэлтийг нь хүлээж авахгүй удаад байна. Яг үнэндээ өнөөдөр өргөн хүрээнд нь харвал монголын төрийн 3 засаглал (шүүх засаглал, хууль тогтоох засаглал, гүйцэтгэх засаглал)-ын хооронд дайн болоод байна.

“УИХ, Цэц хоёр “Эрдэнэт” үйлдвэрийн асуудлаар шийдвэрээ гаргачихсан. Худалдаа хөгжлийн банк “Эрдэнэт” үйлдвэрийн 49 хувийг худалдаж авсан асуудлыг шалгаад бүх материалыг гаргаж, УИХ шийдвэрээ гаргасан” гэж Хууль зүй, дотоод хэргийн сайд хэлсэн. Эрдэнэт үйлдвэрийн захирлыг Засгийн газраас томилох бол “Монголросцветмент”-ийн захирлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас томилно гэж байгаа.

Эрдэнэтийн 49 хувийн асуудал дээр нь Ерөхийлөгчийн яагаад өнөөдрийг болтол дуугарахгүй байгааг гайхаж байна.

С.Зориг агсны хэргээр яллагдсан хоёр хүнийг эрүүдэн шүүсэн байна гэдгийг Хууль зүй, дотоод хэргийн сайд хэлээд, би ар гэрийнхнээс



Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж

нь уучлалт гуйж байна гэсэн. Шүүхээс эдгээр хоёр хүнийг буруу ялласан байна гэдэг мэдэгдэл гарсан уу? Эсвэл гараагүй байхад нь Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайд нь мэдэгдэл хийчихэв үү?

Энэ мэдэгдэл маш ноцтой. Ц.Нямдорж сайдын мэдэгдлийг бүтнээр нь харвал “С.Зоригийн амь настай холбоотой эрүүдэн шүүх ажиллагаа явуулсан нь тодорхой болж байгаа. Би сайдын ажлаа авсны дараа нэг хүнийг ажлаас нь халсан. Энэ бүхэн учиртай. Одоо яг тэр хүн шалгагдаж байгаа. Монголд цаашид үеийн үед 1937 оны хэлмэгдүүлэлт хэзээ ч болохгүй гэж бодож байна. Би тэр хоёр яллагдагчтай очиж уулзсан. Хийгээгүй хэрэгт хилсээр шийтгүүлж, хүйтэн камерт яаж байгааг нь харах гэж би очиж уулзсан. Өчигдөр Ч.Содномдаржаа, Т.Чимгээ хоёрыг эмнэлэгт хэвтүүлсэн. Энэ хоёр хүний ар гэрээс Монголын төрийн өмнөөс уучлалт гуйж байна, би ер нь уучлалт гуйж үзээгүй хүн.”

Хэрвээ энэ мэдэгдэл худлаа юм бол худлаа ярьдаг сайддаа хариуцлага тооц. Хэрвээ үнэхээр ийм маягийн шүүх, прокурорууд байгаа бол үндэс сууриар нь солих ёстой. Тэгэх гэж ардчилал, эрх чөлөөг бий болгосон юм. 2020 оноос өмнө үүнийхээ учрыг олох хэрэгтэй. Хэрвээ чадахгүй бол энэ хоёр намын учрыг иргэд олох хэрэгтэй. Эс тэгвээс дараагийн золиос нь та би ч байж болохоор нөхцөл бий болж байна гэсэн үг.

БАНКУУДЫН ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ БАГАССАНААР ББСБ–ЫГ ЗОРИХ УУ?**Үйл явдлын товч:**

Төв банкны Мөнгөний бодлогын хороо товын дагуу хуралдаж өнгөрсөн 21-ний өдөр шийдвэрээ гаргасан. Шийдвэрээр бодлогын хүүг өөрчлөхгүй 11 хувьд хадгалахаар болсон. Харин банкуудын олгох хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 60 хувь болголоо. Уг хязгаарыг Мөнгөний бодлогын хороо 2018 оны 6-р сарын 15-ны өдрийн хуралдаанаараа 70 хувьд байлгахад болж байсан.

Дүгнэлт тайлбар:**Яагаад бодлогын хүүг хэвээр үлдээв?**

Монголбанк хэцүү байдалд байгаа. Бодлогын хүү гэдэг бол арилжааны банкууд зээл өгөхийн оронд Монголбанк руу шилжүүлсэн мөнгөө жилийн 11 хувиар тооцож ашиг авна гэсэн үг. Гэтэл арилжааны банкны хадгаламжийн хүү нь 13-14%, зээлийн хүү нь 18-19% байгаа. Энэ хоёрын хоорондох 4-5 хувь дээр банкууд ашгаа хийж байгаа. Ийм нөхцөлд яагаад Монголбанк бодлогын хүүгээ 11%-аас доош болгож чадахгүй байгаа вэ гэдэг нь инфляци 7% байгаа учраас юм. Гэтэл Монголбанкнаас хамаарахгүйгээр инфляци нэмэгдээд байгаа. Тэгэхээр бодлогын хүү тийм ч хүссэний зоргоор амархан буурчихгүй л дээ.

БОДЛОГЫН ХҮҮ 11%
ЗЭЭЛИЙН ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦАА
60%
 2019 оны 3-р сар

Хэрэглээний зээлийн өр орлогын харьцааны дээд хязгаарыг 60% болгосон. Энэ нь эдийн засагт хэрхэн нөлөөлөх вэ?

Маш том нөлөөтэй. Хувь хүний ахуй хэрэглээний зардал өндөр байх тусам эдийн засагт ашигтай. Хүмүүс мөнгөгүй болчихоор эдийн засгийн эргэлт (өргөн хэрэглээний бараа, хоол хүнс зэрэг) багасаад эхэлдэг. Ингээд эрэлт нь багасаад эхлэхээр үнээ барихын тулд нийлүүлэлт нь дагаад багасна. Улмаар энэ чинь үйлдвэрлэлийг багасгана гэсэн үг. Тэгээд энэ хоёрын нийлбэр нь эдийн засагт нөлөөлнө.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв

Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх боломжтой.

GOOGLE STORE

APP STORE



WORLD WINE
Vinotage



2nd floor, River Tower
Contact: 7777-4747



JARGAL DEFACTO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette

➤ МОНГОЛ

➤ АНГЛИ

➤ ЯПОН



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ үү.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Баатарчулууны Анударь

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com